



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ᠰᠤᠬᠪᠠᠭᠠᠲᠤ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠳᠡᠷᠭᠡᠳᠡᠬᠡ
ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢ
ᠬᠡᠯᠲᠡᠰ

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2018/12



sukhbaatar.nso.mn

www.1212.mn



Статистикийн хэрэглэгч та бүхэн манай хэвлэмэл бүтээгдэхүүн болон тоо мэдээллүүдийг 1212.mn аппликейшнаар дамжуулан Apple-ын iPhone, iPad төхөөрөмжтэй бол App store-с, андройд үйлдлийн системийн төхөөрөмжтэй бол Google play-с татан авч, суулгаж ашиглах боломжтой.

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХААНААС, ХЭРХЭН АВАХ ВЭ ?

 Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн нэгдсэн сан

www.sukhbaatar.nso.mn

Сүхбаатар аймгийн статистик хэлтсийн вэб хуудас

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Нумын сан 

Мэдлэгээ шалгах тоглоом 

Валютын ханш 







аппликейшнаас
СТАТИСТИКИЙН мэдээллээ авсаарай



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ** бүртгүүлнэ үү 

Энэ хэсэгт өөрийн e-mail хаягаа бүртгүүлснээр статистикийн мэдээллийг цаг алдалгүй тогтмол авч байх болно.

SOCIAL NETWORK



www.facebook.com/Статистик-Мэдээлэл



www.twitter.com/statistic_mn

СҮХБААТАР АЙМАГ



www.facebook.com/statistic



Утсаар:



Лавлах утас

1900-1212

Сүхбаатар аймаг

7051-8203



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**12 сар
2018**

Баруун-Урт сум



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	3
Аргачлалын тайлбар	4-5
Товч танилцуулга	6-22
Үндсэн үзүүлэлтүүд	23

I. Нийгмийн Үзүүлэлт

I.1 Хүн ам	24-30
I.2 Хөдөлмөр	31-33
I.3 Нийгмийн даатгал, нийгмийн халамж	34-35
I.4 Боловсрол	36-42
I.5 Эрүүл мэнд	42-44
I.6 Соёл, урлаг	44
I.7 Газар өмчлөл	45
I.8 Гэмт хэрэг	46-47

II. Эдийн засгийн Үзүүлэлт

II.1 Мөнгө, банк, даатгал	48-49
II.2 Төрийн санхүү	49-52
II.3 Төсөл хөтөлбөр	53-54
II.4 Үнэ	55-56
II.5. Статистикийн бизнес регистрийн сан	57-60
II.6 Хөдөө аж ахуй	60-79
II.7 Аж үйлдвэр	80-82
II.8 Тээвэр, холбоо	83-84
II.9 Барилга	84



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэлгээ:

Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ... XII гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй	x Бүтцийн өөрчлөлт
0.0 Маш бага тоо	+, - Зөрүү
- Гүйцэтгэл байхгүй	* Дахин

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. 18-17 нь 2018 оны үзүүлэлтийн тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

V. "Төл" нь төлөвлөгөөг, "Гүйц" нь гүйцэтгэл.

VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Црх, хн ам:** Энэ бүлэгт хүн амын өсөлт, нас, хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, гэрлэлт, цуцлалт, үрчлэлт зэрэг хүн амын ердийн хөдөлгөөний статистикийн үзүүлэлтүүдийг тусгасан. Хүн ам, өрхийн мэдээллийн сан 2014 оноос эхлэн онлайн горимд шилжиж, баг, сум, аймгийн түвшинд үр дүн гарган, мэдээллийн санг тогтмол шинэчилэн ажиллаж байна.
- **Хүйсийн харьцаа:** 100 эмэгтэйд ногдох эрэгтэйн тоо.
- **Хн ам зүйн ачаалал:** Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгч /хүүхэд, өндөр настан/ хүний тоо.
- **Хн амын жилийн дундаж тоо:** Жилийн эхний болон эцсийн хүн амын тооны нийлбэрийг 2-т хувааж тооцно.
- **Хдлмр, тэтгэвэр, тэтгэмж:** Уг мэдээг холбогдох газар, хэлтсүүд нь гарган нэгтгэж ирүүлдэг.
- **Эрл мэнд:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Соёл, урлаг:** Соёл, урлагийн үйл ажиллагааг эрхэлдэг газрууд нь мэдээг нэгтгэн гаргаж ирүүлдэг.
- **Газар мчлгч иргэдийн** мэдээллийг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар сумдаас авч нэгтгэн ирүүлж байна.
- **Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээг цагдаагийн хэлтсээс нэгтгэн гаргаж ирүүлдэг.
- **Мнг, банк, даатгал:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг. Даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд үндсэн үйл ажиллагааны мэдээллийг гаргаж ирүүлдэг.
- **Трийн санхүү:** 2013 оны 1-р сарын 1-нээс “Төсвийн тухай хууль” шинээр хэрэгжиж эхэлснээр сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, соёлын байгууллагууд, хүүхэд гэр бүлийн хэлтэс, газрын алба, халамж асрамжийн үйлчилгээ зэрэг зардлууд орон нутгийн төсвөөс санхүүжих болсонтой холбоотойгоор төсвийн зардал ихээр нэмэгдэж байна. Мөн орлогын хувьд орон нутагт төвлөрдөг байсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, лицензийн төлбөр нь улсын төсөвт төвлөрдөг болсон.



Дээр нэмэгдэж буй зардлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг орон нутгийн төсөвт оруулдаг болсон. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтсийн үндсэн нэгжээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Төсөл:** Засгийн газрын зарим гол төслүүд болон сангуудын хөрөнгийн зээл ойлголт, үйл ажиллагааны мэдээллийг холбогдох хэлтэс, агентлагууд гаргаж ирүүлдэг.
 - **Аж ахуйн газар** – Хүнс хөдөө аж ахуйн газар
 - Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт – Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.
 - Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Хөдөө аж ахуй:** Хөдөө аж ахуйн тооллого 2018 оны 12-р сарын 7-17-нд явагдаж мэдээлэл цуглуулан, боловсруулалт хийж, улсад мэдээлдэг. 2012 оны жилийн эцсээс тооллогын маягт шинээр батлагдан, програмын вэб технологиор онлайн орчинд шивэгдэхээр боловсруулсныг мөрдөж хэрэгжүүлэн, үр дүнг гарган тархааж, улсад мэдээлж байна.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний төсвийг тооцохдоо: Гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Тээвэр, Холбоо: Уг үйл ажиллагааг эрхэлдэг ААН-нэгжүүд болон сумдын тамгын газрууд мэдээг нэгтгэн гаргаж ирүүлдэг.

- **Статистикийн бизнес регистр:** тодорхой бүтэцтэй тогтмол шинэчлэгдэн статистикийн зорилгоор ашиглагддаг аж ахуйн, нэгж байгууллага юм.



Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2018 оны эцсийн байдлаар)

I. Нийгмийн Өзлэлт



I.1 Өрх, Хүн ам


Оны эцэст өрх, хүн амын тоо урьдчилсан гүйцэтгэлээр 18.3 мянган өрх, 62.5 мянган оршин суугаа хүн амтай болж урьд оноос өрх 263, хүн ам 1165 хүнээр өслөө. Нийт өрхийн 49.3 хувь, хүн амын 50.7 хувь нь хөдөөд амьдарч байна.

Хүн амын 49.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амын 62.7 хувийг 15-59 насныхан, 30.6 хувийг 0-14 насныхан, 6.7 хувийг 60 ба дээш насныхан эзлэх болсноор хүн ам зүйн ачаалал 52.3 хувьтай байна.


Аймгийн хэмжээнд Баруун-Урт сумын 1-р баг 1108 өрх, 3706 хүнээр 67 баг дотор тэргүүлж байна.

2018 онд 702 хүн шилжин ирж, 565 хүн шилжин явсан нь урьд оноос шилжиж ирэгсэд 9.9 хувь буюу 77 хүнээр, шилжин явагсад 9.7 хувь буюу 61 хүнээр тус тус буурчээ. Шилжин ирэгсдээс 44.7 хувь, шилжин явагсдын 81.4 хувь нь Улаанбаатар хот болон аймаг хооронд шилжилт хөдөлгөөнд оролцсон байна.


Зураг I.1.1 Хүн ам, өрхийн тоо, жил бүрийн эцсийн байдлаар



Зураг I.1.2 Хүн амын нас, хүйсний суварга



Зураг I.1.3 Хүн амын тоо, насны бүлгээр






Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр энэ онд шинээр төрсөн 1564 хүүхэд, нас барсан 276 хүн бүртгүүлсэн байна.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр 2018 оны жилийн эцсийн байдлаар 1307 хүүхэд шинээр мэндэлж, 356 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 951 болж, 2017 оноос 0.8 хувь буюу 8-аар буурсан.

1000 хүнд ногдох төрөлт 21.5, нас баралт 5.9 байгаа нь өмнөх онтой харьцуулахад төрөлт адил түвшинд, нас баралт 0.6 пунктээр өссөн байна.

Зураг I.1.4 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо, жил бүрийн эцсийн байдлаар



I.2 Хөдөлмөр

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2018 оны 12 дугаар сарын эцэст 854 болсны 438 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 647 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеэс 27.0 хувь буюу 239 хүнээр буурсан байна.

Жилийн эцсийн байдлаар хөдөлмөр халамж үйлчилгээний газарт 3230 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 938 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Зураг I.2.1 Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд тоо, жил бүр эцсийн байдлаар





Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 58.1 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.6 хувь нь магистр, доктор, 17.8 хувь нь дээд, 2.9 хувь нь тусгай дунд, 8.8 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 48.2 хувь нь бүрэн дунд, 13.8 хувь нь суурь, 6.3 хувь нь бага боловсролтой, 1.5 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Зураг 1.2.2 Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр, 12 сарын байдлаар



2018 оны байдлаар 842 шинэ ажлын байр бий болсон нь өмнөх оны мөн үеэс 38.0 хувь буюу 232-оор өсчээ. Шинэ ажлын байрыг эдийн засгийн ангилалаар нь авч үзвэл боловсруулах үйлдвэр 172 буюу 20.4 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 158 буюу 18.8 хувийг эзэлж байгаа нь өндөр үзүүлэлтэй байна.



1.3 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын шимтгэлийн нийт орлого жилийн эцсийн байдлаар 14.7 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 5.9 хувиар өсчээ. Үүнээс ажил олгогчоос 13.3 тэрбум төгрөгний шимтгэл төлсөн нь өмнөх онтой харьцуулахад 15.6 хувиар өссөн байна.

Аймгийн хэмжээнд сайн дурын даатгуулагчид 920.6 сая төгрөгний шимтгэл төлсөн нь өмнөх онтой харьцуулахад 39.2 хувиар өсчээ.

Жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын сангаас нийт 8.4 мянган иргэнд 27.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосноос, 6.2 мянган өндөр настанд 20.4 тэрбум төгрөг, 1.4 мянган тахир дутуу иргэнд 3.6 тэрбум төгрөг, 433 тэжээгчээ алдсан иргэнд 1.1 тэрбум төгрөг, 320 иргэнд цэргийн тэтгэвэрт 1.9 тэрбум төгрөг, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчтөний даатгалд тус тус бүрэн олгожээ. Нийт тэтгэвэр авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.2 хувиар, олгосон тэтгэврийн хэмжээ 10.1 хувиар тус тус өссөн байна.



Нийгмийн халамжийн сангаас нийт 8.3 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 32.3 мянган иргэнд олгосноос, халамжийн сангаас 5.3 тэрбум төгрөгийг 20.3 мянган иргэнд, улсын төсвөөс 3.0 тэрбум төгрөгийг 12.0 мянган иргэнд тус тус олгожээ.



I.4 Боловсрол

Ерөнхий боловсролын сургууль: 2018-2019 оны хичээлийн жилд 16 сургуульд 11.6 мянган суралцагчид байгаагийн 49.9 хувь болох 5.8 мянга нь эмэгтэй сурагчид байна. Өмнөх оны мөн үеэс сурагчдын тоо 2.5 хувь буюу 279 хүүхдээр өсчээ. Нийт сурагчдын 55.2 хувь болох 6.4 мянга нь 1-5-р ангид, 30.8 хувь болох 3.6 мянга нь 6-9-р ангид, 14.0 хувь болох 1.6 мянга нь 10-12-р ангид суралцаж байна.

Энэ хичээлийн жилд 1-р ангид 1.4 мянган сурагч элсэн орсны 50.0 хувь болох 685 нь эмэгтэй сурагч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 8.2 хувь буюу 37 сурагчаар буурсан байна. Мөн 12-р ангид 0.3 мянган сурагч байгаагийн 54.3 хувь буюу 166 нь эмэгтэй сурагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.5 дахин буюу 255 сурагчаар буурчээ.

Энэ хичээлийн жилд 402 бүлэг хичээллэж байгаа бөгөөд нэг ангид 29 сурагч ногдож байна. 1 багшид ногдох сурагчийн тоо 20 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй адил түвшинд байна. Нийт ажиллагсдын 57.3 хувь болох 576 нь үндсэн багш байна. Үүний 78.6 хувь болох 453 нь эмэгтэй багш нар байна. Өмнөх оны мөн үеэс багш нарын тоо 0.8 хувиар буурсан байна.

Дотуур байранд 952 сурагч амьдарч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар буурчээ.

Зураг I.4.1 Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо



Ерөнхий боловсролын сургуулийг 2017-2018 оны хичээлийн жилд 2764 сурагчид төгсчээ. Үүнээс: бага боловсролыг 1033, суурь боловсролыг 1016, бүрэн



дунд боловсролыг 715 сурагчид тус тус эзэмшжээ. Өнгөрсөн оны мөн үеэс нийт төгсөгчдийн тоо 259 буюу 10.3 хувиар өссөн байна.

Нийт төгсөгчдийн 37.4 хувь нь бага, 36.7 хувь нь суурь, 25.9 хувь нь бүрэн дунд боловсролтой болсны 55.1 хувь буюу 1280 нь эмэгтэй сурагчид байна.

Зураг I.4.2 Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн тоо



Сургуулийн өмнөх боловсрол: 2018-2019 оны хичээлийн жилд 24 цэцэрлэгийн 167 бүлэгт 5.4 мянган хүүхэд хүмүүжиж байгаагийн 49.4 хувь буюу 2.7 мянга нь эмэгтэй хүүхэд байна. Өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар буюу 79 хүүхдээр өсчээ. Нийт хүмүүжиж байгаа хүүхдийн 4.3 мянга болох 79.3 хувь нь үндсэн цэцэрлэгт, 1.1 мянга болох 20.7 хувь нь хувилбарт сургалтанд хамрагджээ. Нийт ажиллагсдын 27.8 хувь болох 162 нь үндсэн багш байна.

Зураг I.4.3 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо



Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: Сүхбаатар аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2018-2019 оны хичээлийн жилд 16 мэргэжлээр 330 суралцагчид суралцаж байгаагийн 38.5 хувь болох 127 нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс нийт суралцагчдын тоо 10.4 хувь болох 31 суралцагчаар өссөн байна.

Нийт суралцагчдын 62.7 хувь болох 207 нь мэргэжлийн боловсрол эзэмшихээр сурч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 20.1 хувь буюу 52



суралцагчаар буурсан байна. Мэргэжил олгох 1 жилийн сургалтанд 123 хүн сурч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.1 дахин буюу 83 хүнээр өссөн байна. Нийт суралцагчдын 15.5 хувь нь тогооч, 14.5 хувь нь барилгын засал чимэглэгч, 7.9 хувь нь автомашины засварчин, 8.2 хувь нь гоо засалч, 7.9 хувь нь барилгын өрөгч угсрагч мэргэжлээр сурч байгаа нь олонх байна. Нийт ажиллагсдын 39.2 хувь нь болох 20 үндсэн багш байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 2-оор буурсан байна.

Зураг I.4.4 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдын тоо



Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг 2017-2018 оны хичээлийн жилд: 7 мэргэжлээр 166 хүүхэд төгссөний 68 буюу 41.0 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Нийт төгсөгчдийн 120 буюу 72.3 хувь нь мэргэжлийн боловсрол эзэмшчээ. Харин 27.7 хувь нь болох 46 хүн мэргэжлийн сургалтанд сурч төгссөний 17 буюу 37.0 хувь эмэгтэй хүн байна. Эдгээр төгсөгчдийн 17 буюу 37.0 хувь нь оёмол бүтээгдэхүүний оёдолчин, 29 буюу 63.0 хувь нь барилгын засал чигмэглэлчиний мэргэжил эзэмшжээ. Нийт төгсөгчид нь өмнөх оны мөн үеэс 1 буюу 0.6 хувиар буурчээ. Нийт төгсөгчдөөс 53 хүүхэд ажлын байртай болсон бөгөөд үүнийг ангилбал: мэргэжлээрээ ажилд орсон 24, 3 сарын дотор ажилд орсон 17, 3 сарын дараа ажилд орсон 12 хүүхэд байна.

Зураг I.4.5 Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчдийн тоо






1.5 Эрүүл мэнд

2018 оны жилийн эцсийн байдлаар 233.4 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оноос 4.1 хувиар буурч, 13.6 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь 3.8 хувиар өссөн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 74.1 мянган хүн хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 14.5 хувиар буурчээ.

Түргэн тусламжийн дуудлага 17.5 мянган удаа гарсны 4.2 мянга буюу 24.0 хувь нь алсын дуудлага байна. Өнгөрсөн онтой харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 1.2 хувиар өсч, алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар буурсан байна.

Аймгийн хэмжээнд 1300 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 1307 хүүхэд болж, өмнөх оноос амаржсан эхийн тоо 25 буюу 2.0 хувиар, хүүхдийн тоо 32 буюу 2.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1.5.1 Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



Энэ оны эцэст нялхсын эндэгдэл 14 болж, өмнөх оны мөн үеэс 8 хүүхэд буюу 36.4 хувиар буурч, 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 7 болж өмнөх оны мөн үеэс 3 хүүхэд буюу 75.0 хувиар өссөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо жилийн эцэст 678 болж, өнгөрсөн оноос 598 хүн буюу 46.7 хувиар буурсан байна. Гар хөл амны өвчнөөр өвчлөгчид 244 буюу 87.1 хувь, салхинцэцгээр өвчлөгчид 195 буюу 56.5 хувь, тэмбүү өвчнөөр өвчлөгчид 97 буюу 33.1 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.



1.6 Соёл, урлаг

Хөгжимт жүжгийн театр: 2018 онд өөрийн байранд болон явуулын тоглолтыг 8.6 мянган үзэгчдэд 28 уран бүтээлээр үйлчлэн 15.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс тоглолтын тоо 75 хувиар, үзэгчдийн тоо 8.9 хувиар тус тус өсчээ. Үндсэн тоглолтын 3.6 хувь нь жүжиг, 32.1 хувь нь концерт, 64.3 хувийг бусад тоглолт эзэлж байна. Нийт тоглолтын 21.4 хувь нь гадны тоглолт эзэлж байна.



Зураг I.6.1 Нийт тоглолт, үзэгчдийн тоо



Музей: Аймгийн Угсаатны зүйн музей 2.1 мянган үзмэрээр 4.1 мянган хүнд үйлчилж 3.7 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх оны мөн үеэс үзэгчдийн тоо 2.1 мянгаар, үзмэрийн тоо 47-оор, орлого нь 2.3 дахин тус тус өссөн байна.

Зураг I.6.2 Музейн үндсэн үзүүлэлтүүд



Номын сан: Аймгийн нийтийн номын сан нь 46.8 мянган номоор давхардсан тоогоор 14.4 мянган уншигчдад үйлчилжээ. Өмнөх оны мөн үеэс номын тоо 0.3 мянгаар, харин уншигчдын тоо 9.1 хувиар тус тус өсчээ.

Зураг I.6.3 Номын сангийн үндсэн үзүүлэлтүүд






I.7 ГАЗАР ӨМЧЛӨЛ


Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 10.5 мянган иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 10.0 мянган иргэнд 901.95 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байна.

Энэ онд аж ахуйн зориулалтаар газар өмчлөхийг хүссэн 25 иргэний өргөдөл ирсэнийг 100 хувь шийдвэрлэжээ.

Зураг I.7.1 Газар өмчлөх өргөдөл гаргасан иргэдийн тоо



Зураг I.7.2 Засаг даргын гаргасан иргэдийн тоо



I.8 Гэмт хэрэг

2018 оны жилийн эцэст аймгийн хэмжээнд нийт 366 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 22 хүн нас барж, 154 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оноос 28-аар өсчээ.


Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 0.8 тэрбум төгрөгийн хохирол учирсны 59.0 хувийг нөхөн төлүүлжээ. Гэмт хэрэгт 275 хүн холбогдон сэжиглэгдсэний 34.2 хувь нь согтуугаар, 8.4 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 550 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оноос 12.2 хувь буюу 60 хүнээр өсчээ. Эрүүлжигдсэн нийт хүмүүсээс 131 хүн баривчлагдан захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 62.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.5 пунктээр буурсан байна.



Зураг I.8.1 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



II. Эдийн засгийн үзүүлэлт




II.1 Мөнгө, банк, даатгал

Монгол банкны мэдээгээр ХААН, Төрийн, Хас, Голомт, Капитал банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 143.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 56.7 тэрбум төгрөгөөр буюу 24.8 хувиар өссөн байна.

Банкуудад хадгалуулсан төгрөгийн хадгаламжийн хэмжээ 79.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 23.1 тэрбум төгрөгөөр буюу 40.8 хувиар өссөн байна.

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 0.7 тэрбум болж өмнөх оны мөн үеэс 2.1 тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг II.1.1 Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл, тэрбум.төг



Даатгал: Даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 627.9 сая төгрөг болж, өмнөх оноос 6.6 хувиар өссөн байна.

Энэ онд 591 хүнд 123.2 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосны дотор авто тээврийн хэрэгсэлд 17.9 сая, гэнэтийн осолд 11.1 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 12.0 сая, жолоочийн хариуцлагад 56.0 сая, хүүхдийн гэнэтийн ослын



даатгалд 22.0 сая, малын индексжүүлсэн даатгалд 3.7 сая төгрөгийг тус тус олгожээ. Энэ нь өмнөх оноос нөхөн төлбөр авсан хүний тоо 3.1 хувиар буурч, нөхөн төлбөрийн хэмжээ 34.9 хувиар өсчээ.

Авто тээврийн төвийн мэдээгээр 2018 оны жилийн эцэст 23.9 мянган иргэн 9.6 сая төгрөгний амь даатгалд хамрагджээ.

Малын индексжүүлсэн даатгалд 13 сумын 290 өрхийн 107.5 мянган малыг 69.5 сая төгрөгөөр даатгуулсан. Төрлөөр авч үзвэл: 50.8 мянган хонь, 42.9 мянган ямаа, 12.9 мянган үхэр, 5.0 мянган адуу, 0.1 мянган тэмээ даатгалд хамрагджээ. байна.

Авто тээврийн үндэсний төвийн мэдээгээр 2018 онд Улаанбаатар хот руу зорчсон нийт 23.9 мянган иргэн 9.6 сая төгрөгийн амь даатгалийн хураамж төлсөн байна.

Зураг II.1.2 Даатгалын төрлөөр



II.2 Төрийн санхүү

Аймгийн төсвийн нийт орлого 2018 оны жилийн эцсийн байдлаар 55.3 тэрбум төгрөг болж өмнөх оноос 5.4 тэрбум төгрөг буюу 10.8 хувиар өсчээ.


Нэгдсэн төсвийн 20.6 хувийг орон нутгийн төсвийн орлого, 12.6 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 52.6 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 4.8 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох дэмжлэг, 9.4 хувийг урьд оны үлдэгдэл эзэлж байна.

Төсвийн зарлага санхүүжилт 54.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 4.7 тэрбум төгрөг буюу 9.4 хувиар өсчээ.

Жилийн эцсийн байдлаар аймгийн нийт хөрөнгө оруулалт 5.5 тэрбум төгрөг байна.



Зураг II.2.1 Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг



II.3 Төсөл хөтөлбөр: Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төсөлд нийт ААНБ болон иргэдээс нийт 81 төсөл ирснээс 65 төсөлд 484.9 сая төгрөг олгосон байна.

Аймгийн хэмжээнд 48 өрхийг малжуулах хөтөлбөрт хамруулан, 225.0 сая төгрөгөөр малжуулаад байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрын дэмжих хөтөлбөрийн хэмжээнд 15 иргэнд 40.0 сая төгрөг, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 9 иргэнд 27.0 сая төгрөг, нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөрийн хэмжээнд 360 иргэнд 67.2 сая төгрөг, ахмад настны зөвлөх үйлчилгээнд 9 иргэнд 12.0 сая төгрөг, хүнсний ногоо тариалах хөтөлбөрийн хүрээнд 52 иргэнд 13.7 сая төгрөг, мөн 72 иргэнд 600.0 сая төгрөгийн жижиг зээлийг тус тус олгосон.



II.4 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс 2018 оны 12 дугаар сарын байдлаар өмнөх сараас 0.1 хувь, өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар тус тус өслөө.



Хүснэгт II.4.1 Хэрэглээний үнийн индекс, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	2018.XII	2018.XII	2018.XII
	2015.XII	2017.XII	2018.XI
Ерөнхий индекс	114.4	107.0	100.1
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	111.3	107.1	100.8
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	114.1	101.6	100.2
Хувцас, бөс бараа, гутал	120.3	113.6	100.0
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	106.7	102.5	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	110.9	103.0	100.1
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	124.1	105.1	98.9
Тээвэр	120.1	109.8	99.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.8	104.1	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	105.5	101.4	99.9
Боловсролын үйлчилгээ	117.8	101.5	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	107.1	106.8	100.0
Бусад бараа, үйлчилгээ	114.8	103.1	100.2

Ерөнхий индекс мнх сарынхаас **0.1 хувиар** өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 0.8 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисны бүлгийн үнэ 0.2 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.1 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 0.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**II.5 Статистикийн бизнес регистрийн сан**

Статистикийн бизнес регистрийн санд 2018 оны эцэст 1053 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 806 буюу 76.5 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Өмнөх оны мөн үеэс үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 45 буюу 5.9 хувиар өсчээ.

Бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хариуцлагын хэлбэрээр нь нь авч үзвэл ХХК нь 50.7 хувь, төсөвт байгууллага 16.1 хувь, төрийн бус байгууллага 16.6 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна.

Ажиллагчдын тоогоор нь авч үзвэл 80.9 хувь нь 1-9, 6.2 хувь нь 10-19, 8.9 хувь нь 20-49, 3.1 хувь нь 50-иас дээш тус тус ажиллагчидтай байна. Үйл ажиллагаа явуулаагүй 247 аж ахуйн нэгж, байгууллагыг шалтгаанаар авч үзвэл үйл ажиллагаагаа эхлээгүй 90 буюу 36.4 хувь нь, түр зогсоосон 108 буюу 43.7 хувь нь, бүрэн зогсоосон 49 буюу 19.8 хувийг тус тус эзэлж байна.

Эдийн засгийн салбарын ангилалаар нь авч үзвэл бөөний болон жижиглэн худалдаа гэр ахуйн барааны үйлчилгээнд 263 буюу 32.6 хувь,



Үйлчилгээний бусад үйл ажиллагаанд 125 буюу 15.5 хувь, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаанд 64 буюу 7.9 хувь, Хөдөө аж ахуйн, ан агнуур, ойн аж ахуйн салбарт 54 буюу 6.7 хувь, боловсролын салбарын үйл ажиллагаанд 52 буюу 6.5 хувь, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын үйл ажиллагаанд 49 буюу 6.1 хувь, зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаанд 38 буюу 4.7 хувийг тус тус эзэлж байгаа нь хамгийн өндөр байна.



II.6 Хөдөө аж ахуй

Малтай болон малчин өрх, малчид: Энэ онд 10.2 мянган өрх, 54 аж ахуй нэгж, байгууллагад нийтдээ 3.7 сая толгой мал тоолууллаа. Нийт малтай өрхийн дотор мал бүхий 2.4 мянган өрх, малчин 7.8 мянган өрх, тавиул малтай 28 өрх байна. Хөдөө аж ахуйн тооллогын дүнгээр мал аж ахуйн салбарт 14.6 мянган малчид ажиллаж байна.


Нийт малтай өрхийн 44.4 хувийг 200 хүртлэх малтай өрх эзэлж байгаа нь урьд оноос 1.4 пунктээр буурч, 200-аас дээш малтай өрхийн тоо урьд оноос 1.4 пунктээр өссөн байна. 773 өрх мянгаас дээш мал тоолуулж, шинээр 124 мянгат малчин төрлөө.

Мал аж ахуй: Мал сүрэг урьд оноос 5.3 хувь буюу 188.4 мянгаар өсч, 3.7 сая мал тоологдсоны дотор тэмээ 8.2 мянга, адуу 327.3 мянга, үхэр 251.6 мянга, хонь 1.9 сая, ямаа 1.2 сая толгой болжээ.

Аймгийн дүнгээр малын тоо 4 төрөл дээр өссөн байна. Сумдаар авч үзвэл Асгат, Баяндэлгэр, Онгон, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Түмэнцогт сум 5 төрөл дээр, Дарьганга, Наран сум 4 төрөл дээр, Түвшинширээ сум 3 төрөл дээр, бусад сумд 1 төрөл дээр өсчээ.

Аймгийн хэмжээнд Баяндэлгэр сум 466.0 мянган буюу нийт мал, мөн 251.1 мянган хониор, 167.0 мянган ямаагаар, Түвшинширээ сум 1.3 мянган тэмээгээр, Эрдэнэцагаан сум 46.7 мянган адуугаар, Баруун-Урт сум 29.5 мянган үхрээр аймагтаа тэргүүлээ.

Зураг II.6.1 Малын тоо, мянган толгой, жил бүр эцсийн байдлаар





Хээлтэгч мал 1.6 сая тоологдсон нь нийт малын 43.9 хувийг эзэлж байна. Оны эхний эх малын 87.0 хувь буюу 1.2 сая мал төллөж, 1.2 сая төл бойжуулж авлаа.

Оны эхний малын 2.2 хувь болох 76.0 мянган том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеийнхээс 63.0 мянган толгой малаар буюу 5.9 дахин өссөн байна. Том малын хорогдлыг төрлөөр нь авч үзвэл: тэмээ 38, адуу 4.1 мянга, үхэр 7.2 мянга, хонь 30.4 мянга, ямаа 34.2 мянга толгой байна. Зүй бусаар хорогдсон том малын 0.2 хувь болох 141 мянган толгой мал өвчнөөр хорогдсон нь өмнөх оноос буурсан байна.

Газар тариалан: Энэ онд үр тариа 5.1 мян.га-д, төмс 57.2 га-д, хүнсний ногоо 29.5 га-д, тэжээлийн ургамал 150.0 га-д, техникийн ургамал 1.6 мян га-д тариалж, 2.6 мянган тн үр тариа, 527.7 тн төмс, 244.8 тн хүнсний ногоо, 492.0 тн техникийн ургамал хурааж авсан нь урьд оноос үр тариа 744.5 тн буюу 39.3 хувиар өсч, төмс 44.7 тн буюу 7.8 хувь, хүнсний ногоо 11.1 тн буюу 4.4 хувь, техникийн ургамал 98.0 тн буюу 16.6 хувиар тус тус өссөн байна. Харин тэжээлийн ургамлын хувьд энэ онд 892.5 тн ургац авсан байна.

Зураг II.6.2 Тариалсан талбай га-р, 2018 он



Зураг II.6.3 Ургац хураалт, хадлан тэжээл, тн-оор, 2018 он



Хадлан 15.0 мянган тн өвс, хужир шүү 7.2 мянган тн, гар тэжээл 341.7 тн тус тус бэлтгэсэн нь өмнөх оноос бэлтгэсэн өвс 12.9 мян.тн буюу 46.3 хувь, хужир шүү 0.7 мянган тн буюу 9.1 хувиар буурч, бэлтгэсэн гар тэжээл 104.6 тн буюу 44.1 хувиар өссөн байна.



II.7 Аж Үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр 55.0 тэрбум төгрөг болж өмнөх оноос 4.2 тэрбум төгрөг буюу 8.3 хувиар өсчээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 3.2 тэрбум төгрөг буюу 0.4 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 1.4 тэрбум төгрөг буюу 29.6 хувь, уул уурхай,



олборлох аж үйлдвэрийн салбарынх 50.3 тэрбум төгрөг буюу 8.3 хувиар тус тус өссөн байна.

Оны үнээр 283.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 37.8 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс төмрийн хүдрийн баяжмал, хайлуур жонш хайлуур жоншны баяжмал, хайрга, цайрын баяжмал, цахилгаан, ааруул, архи, бууз, банш, боловсруулсан сүү, бялуу, зайрмаг, талх, тараг, цэвэр ус, хэвийн боов, хэрчсэн гурил, ажлын хувцас, туурга, уул уухайн зориулалтын уут, шуудай, гал тогооны өрөөний модон тавилга, цаасан уут, тор зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс өссөн байна.



II.8 Тээвэр, холбоо

Тээвэр: Авто тээвэр бүхий байгууллагууд энэ онд 221.1 мян.тн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 40.0 мян.тн буюу 29.2 хувиар өсчээ.

Мөн давхардсан тоогоор 79.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс зорчигчдын тоо 37.0 мянган хүн буюу 87.9 хувиар өсчээ.

Тээврийн хэрэгслийн тооллогын дүнгээр 9.1 мянган тээврийн хэрэгсэл үзлэг тооллогод хамрагдсан нь өмнөх оноос 2.0 хувиар өссөн байна. Тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл: 86.4 хувь буюу 7.9 мянга нь автомашин, 9.8 хувь буюу 0.9 мянга нь мотоцикль, 2.8 хувь буюу 0.3 мянган нь чиргүүл, 1.0 хувь буюу 0.1 мянган нь механизм байна.

Шуудан, холбоо: Холбооны үйлчилгээний орлого 594.8 сая төгрөгт хүрсний 96.8 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Өмнөх оны мөн үеэс холбооны орлого 1.8 хувиар өсч, хүн амаас орох орлого 20.8 хувиар буурчээ.

Шуудан үйлчилгээний газар нь 38.4 мянган хэвлэл захиалуулж, 10.5 мянган бичиг захидал, 0.3 мянган илгээмжийг явуулж ажилласан нь өмнөх оны мөн үеэс хэвлэл захиалга 49.2 хувиар, илгээмж үйлчилгээ 25.0 хувь, бичиг захидал 2.8 хувиар тус тус буурчээ.

Бичиг захидал 6.8 мянга, илгээмж 1.0 мянга, хэвлэл 76.9 мянгыг хүлээн авч, албан байгууллага, иргэдэд хүргэж үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс бичиг захидал 2.9 хувь, хэвлэл 28.3 хувиар тус тус буурч, илгээмжийн үйлчилгээ өмнөх оны түвшинд байна.

Телефон цэгийн тоо 483 болж, өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар буурсан байна.



II.8.1 ХОЛБООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ.



II.9 Барилга

Барилгын байгууллагууд энэ онд нийт 21.0 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 2.3 тэрбум төгрөг буюу 11.2 хувь нь аймгийн барилгын байгууллага, 18.7 тэрбум төгрөг буюу 88.8 хувь нь гадны барилгын байгууллагууд хийж гүйцэтгэсэн байна.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эцсийн байдлаар

	Хэмжих нэгж	2016	2017	2018	Зөрүү	$\frac{2018}{2017}$ %
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд						
Өрхийн тоо	өрх	17 561	18 005	18 268	263	101.5
Суурин хүн ам	хүн	60 032	61 323	62 488*	1 165	101.9
Төрсөн хүүхэд	хүн	1 262	1 275	1 307	32	102.5
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	761	886	647	- 239	73.0
Суралцагчид, бүгд	хүүхэд	10 764	11 284	11 563	279	102.5
үүнээс: 1-р ангид суралцагчид	хүүхэд	1 233	1 484	1 371	- 113	92.4
Төгсөгчид, бүгд	хүүхэд	2 073	2 505	2 764	259	110.3
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	1 294	1 276	678	- 598	53.1
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	319	338	366	28	108.3
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт						
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар						
	хувь	101.6	105.9	107.0	1.1	101.0
Иргэдийн хадгаламж						
	сая.төг	41 154.0	56 680.0	79 824.4	23 144.4	140.8
Зээлийн өрийн үлдэгдэл						
	сая.төг	99 868.2	115 055.4	143 634.1	28 578.7	124.8
Орон нутгийн төсвийн орлого						
	сая.төг	51 809.1	47 006.8	51 780.4	4 773.6	110.2
Орон нутгийн төсвийн зарлага						
	сая.төг	51 653.3	54 244.1	55 077.8	833.7	101.5
Малтай өрх						
	өрх	9 852	10 073	10 220	147	101.5
Малчин өрх						
	өрх	7 256	7 625	7 770	145	101.9
Малчдын тоо						
	хүн	14 835	14 775	14 585	- 190	98.7
Малын тоо, бүгд						
	мянган.тол	3 030.4	3 528.4	3 716.8	188.4	105.3
Хувийн малын тоо, бүгд						
	мянган.тол	2 999.5	3 493.8	3 683.4	189.6	105.4
Хээлтэгч, бүгд						
	мянган.тол	1 365.5	1 511.2	1 633.3	122.1	108.1
Бойжуулсан төл, бүгд						
	мянган.тол	994.8	1 189.1	1 274.5	85.4	107.2
Том малын зүй бусын хорогдол, бүгд						
	тол	185 646	12 941	75 983	63 042	5.9*
Үүнээс: Өвчнөөр хоргдсон мал						
	тол	692	4 648	141	-4 507	3.0
Тариалсан талбай						
Үүнээс: Үр тариа	га	9 807.0	7 481.0	5 142.0	-2 339.0	68.7
Төмс	га	61.9	65.4	57.2	- 8.2	87.5
Хүнсний ногоо	га	30.0	32.8	29.5	- 3.3	89.9
Хураасан ургац						
Үүнээс: Үр тариа	тн	1 820.6	1 894.5	2 639.0	744.5	139.3
Төмс	тн	514.6	572.4	527.7	- 44.7	92.2
Хүнсний ногоо	тн	245.8	255.9	244.8	- 11.1	95.7
Бэлтгэсэн өвс						
	тн	49 236.0	27 891.1	14 972.5	-12 918.6	53.7
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн						
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая.төг	152 739.1	245 503.5	283 302.1	37 798.6	115.4
Тээврийн орлого						
	сая.төг	9 707.0	12 527.8	12 086.9	- 440.9	96.5
Тээсэн ачаа						
	мян.тн	230.8	171.1	221.1	50.0	129.2
Зорчигч тээвэрлэлт						
	мян.хүн	44.6	42.1	79.1	37.0	187.9
Холбооны орлого						
Үүнээс: Хүн амын	сая.төг	92.4	122.2	96.8	- 25.4	79.2
Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр						
	сая.төг	17 394.5	7 972.1	20 972.1	13 000.0	263.1

*-Хүн амын тоо урьдчилсан гүйцэтгэлээр



I.1.1. ОРШИН СУУГАА ХҮН АМЫН ТОО, СУМААР, НАСНЫ БҮЛГЭЭР

Сум	НАСНЫ БҮЛЭГ												Хүн ам		
	0-14			15-34			35-59			60 +			Бүгд	Үүнээс:	
	Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:				
	Эр	Эм	Эр		Эм	Эр		Эм	Эр		Эм	Эр	Эм		
Ас	532	277	255	608	331	277	610	305	305	125	52	73	1 875*	965	910
Бд	1 520	766	754	1 680	873	807	1 511	749	762	315	119	196	5 026*	2 507	2 519
Да	837	440	397	1 026	519	507	1 020	513	507	197	69	128	3 080*	1 541	1 539
Мх	1 470	754	716	1 588	825	763	1 455	756	699	306	121	185	4 819*	2 456	2 363
На	450	218	232	530	289	241	551	286	265	105	37	68	1 636*	830	806
Он	1 141	596	545	1 245	648	597	1 189	593	596	255	103	152	3 830*	1 940	1 890
Сү	987	544	443	1 140	621	519	1 072	562	510	182	81	101	3 381*	1 808	1 573
Тш	1 066	567	499	1 155	613	542	973	511	462	193	70	123	3 387*	1 761	1 626
Тц	698	345	353	807	427	380	785	393	392	198	80	118	2 488*	1 245	1 243
Уб	829	417	412	961	516	445	940	501	439	206	83	123	2 936*	1 517	1 419
Ха	480	235	245	555	304	251	588	316	272	115	41	74	1 738*	896	842
Эц	2 133	1 088	1 045	2 346	1 254	1 092	1 955	1 017	938	352	145	207	6 786*	3 504	3 282
Бу	6 964	3 562	3 402	6 689	3 316	3 373	6 191	3 023	3 168	1 662	648	1 014	21 506*	10 549	10 957
Дүн	19 107	9 809	9 298	20 330	10 536	9 794	18 840	9 525	9 315	4 211	1 649	2 562	62 488*	31 519	30 969

Тайлбар: Сүхбаатар аймагт оршин суугаа гадаадын иргэн орсон.

*-Хүн амын тоо урьдчилсан гүйцэтгэлийн дүн

хүснэгт I.1.1-ийн үргэлжлэл

Сум	Хүн амаас		рх			Бүх хүн амд эзлэх хувь							Хүн ам зүйн ачаалал
	аймаг, сумын төвд	хөдөөд	Бүгд	үүнээс:		эм	0-14	15-34	35-59	60+	аймаг, сумын төвд	хөдөөд	
				аймаг, сумын төвд	хөдөөд								
Ас	583*	1 292*	555	183	372	48.5	28.4	32.4	32.5	6.7	31.1	68.9	46.9
Бд	897*	4 129*	1 398	262	1 136	50.1	30.2	33.4	30.1	6.3	17.8	82.2	50.6
Да	1 131*	1 949*	911	353	558	50.0	27.2	33.3	33.1	6.4	36.7	63.3	45.0
Мх	1 179*	3 640*	1 459	361	1 098	49.0	30.5	33.0	30.2	6.3	24.5	75.5	52.4
На	410*	1 226*	486	136	350	49.3	27.5	32.4	33.7	6.4	25.1	74.9	44.7
Он	1 055*	2 775*	1 038	307	731	49.3	29.8	32.5	31.0	6.7	27.5	72.5	50.3
Сү	680*	2 701*	1 016	201	815	46.5	29.2	33.7	31.7	5.4	20.1	79.9	47.2
Тш	741*	2 646*	978	217	761	48.0	31.5	34.1	28.7	5.7	21.9	78.1	53.9
Тц	1 009*	1 479*	766	324	442	50.0	28.1	32.4	31.6	8.0	40.6	59.4	47.5
Уб	760*	2 176*	861	231	630	48.3	28.2	32.7	32.0	7.0	25.9	74.1	47.8
Ха	688*	1 050*	520	207	313	48.4	27.6	31.9	33.8	6.6	39.6	60.4	46.1
Эц	2 802*	3 984*	1 912	803	1 109	48.4	31.4	34.6	28.8	5.2	41.3	58.7	51.4
Бу	18 219*	3 287*	6 368	5 420	948	50.9	32.4	31.1	28.8	7.7	84.7	15.3	58.2
Дүн	30 154*	32 334*	18 268	9 005	9 263	49.6	30.6	32.5	30.1	6.7	48.3	51.7	52.3

*-Хүн амын тоо урьдчилсан гүйцэтгэлийн дүн



I.1.2 ӨРХ, ХҮН АМЫН ТОО, багуудаар

Сум	Багийн			Өрхийн тоо	Хүн амын тоо		
	д/д	нэр			Бүгд	Эр	Эм
1	2	3	4	5	6	7	8
Асгат	1	1	Өлзийт	105	364*	197	167
	2	2	Дөхөм	125	463*	241	222
	3	3	Их-Уул	142	465*	249	216
	4	4	Жаргалант	183	583*	278	305
			Сумын дүн	555	1 875*	965	910
Баяндэлгэр	5	1	Баян	234	835*	433	402
	6	2	Дэлгэр	208	769*	380	389
	7	3	Төв	191	699*	344	355
	8	4	Дөхөм	267	974*	485	489
	9	5	Хонгор	236	852*	429	423
	10	6	Ширээт	262	897*	436	461
		Сумын дүн	1 398	5 026*	2 507	2 519	
Дарьганга	11	1	Үүд	180	639*	331	308
	12	2	Бадрах	214	767*	386	381
	13	3	Аман-Ус	164	543*	268	275
	14	4	Овоот	353	1 131*	556	575
			Сумын дүн	911	3 080*	1 541	1 539
Мөнххаан	15	1	Баянтэрэм	298	1 016*	521	495
	16	2	Баян-уул	273	921*	466	455
	17	3	Баянцагаан	314	1 015*	544	471
	18	4	Баясгалант	361	1 179*	581	598
	19	5	Бүрэнцогт	213	688*	344	344
			Сумын дүн	1 459	4 819*	2 456	2 363
Наран	20	1	Гүн худаг	152	514*	266	248
	21	2	Тосонгийн гол	198	712*	366	346
	22	3	Наран булаг	136	410*	198	212
			Сумын дүн	486	1 636*	830	806
Онгон	23	1	Ихбулаг	258	1 012*	508	504
	24	2	Шарбүрд	180	682*	339	343
	25	3	Нүдэн	259	957*	487	470
	26	4	Цөнгөрөг	135	494*	271	223
	27	5	Хавирга	206	685*	335	350
			Сумын дүн	1 038	3 830*	1 940	1 890
Сүхбаатар	28	1	Баянгол	235	753*	410	343
	29	2	Хайлаастай	201	680*	327	353
	30	3	Хулгар	280	1 043*	540	503
	31	4	Ланз	155	478*	264	214
	32	5	Шинэбулаг	145	427*	267	160
			Сумын дүн	1 016	3 381*	1 808	1 573

*-Хүн амын тоо урьдчилсан гүйцэтгэлийн дүн



Нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулга

хүснэгт I.1.2-ын үргэлжлэл							
1	2	3	4	5	6	7	8
Түвшинширээ	33	1	Сэргэлэн	217	741*	376	365
	34	2	Өлзийт	189	669*	359	310
	35	3	Үнэгд	168	579*	307	272
	36	4	Дэлгэрхаан	152	508*	267	241
	37	5	Өгөөмөр	252	890*	452	438
			Сумын дүн	978	3 387*	1 761	1 626
Түмэнцогт	38	1	Лхүмбэ	233	799*	413	386
	39	2	Баянцагаан	209	680*	350	330
	40	3	Баян-Овоо	173	516*	246	270
	41	4	Баянцогт	151	493*	236	257
			Сумын дүн	766	2 488*	1 245	1 243
Уулбаян	42	1	Баян	245	861*	433	428
	43	2	Жаргалант	231	760*	378	382
	44	3	Тэгш	186	654*	340	314
	45	4	Жавхлант	90	305*	175	130
	46	5	Дэлгэр	109	356*	191	165
			Сумын дүн	861	2 936*	1 517	1 419
Халзан	47	1	Халзан шанд	125	471*	248	223
	48	2	Сахиулын шанд	79	245*	133	112
	49	3	Сайншанд	109	334*	170	164
	50	4	Хатавч	207	688*	345	343
			Сумын дүн	520	1 738*	896	842
Эрдэнэцагаан	51	1	Хөндлөн хайлааст	274	1 021*	533	488
	52	2	Цагаан овоо	309	1 081*	566	515
	53	3	Бадрах	188	706*	370	336
	54	4	Хонгор	161	588*	300	288
	55	5	Билүүт	290	1 027*	520	507
	56	6	Жаргалант	208	719*	371	348
	57	7	Хадын булан	228	776*	406	370
	58	8	Алтан овоо	254	868*	438	430
			Сумын дүн	1 912	6 786*	3 504	3 282
Баруун-Урт	59	1	1-р баг	1108	3 706*	1 790	1 916
	60	2	2-р баг	487	1 680*	821	859
	61	3	3-р баг	481	1 651*	801	850
	62	4	4-р баг	755	2 401*	1 177	1 224
	63	5	5-р баг	884	2 968*	1 439	1 529
	64	6	6-р баг	522	1 749*	835	914
	65	7	7-р баг	763	2 505*	1 208	1 297
	66	8	8-р баг	948	3 287*	1 703	1 584
	67	9	9-р баг	420	1 559*	775	784
			Сумын дүн	6 368	21 506*	10 549	10 957
Аймгийн дүн				18 268	62 488*	31 519*	30 969*

*-Хүн амын тоо урьдчилсан гүйцэтгэлийн дүн



I.1.3 ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ, аймгийн дүн, өрхөөр

№	Үзүүлэлт	2017		2018	
		Тоо	Нийт өрхөд эзлэх %	Тоо	Нийт өрхөд эзлэх %
1	Аймгийн нийт Өрхийн тоо	18 005	100.0	18 268	100.0
2	Байршил: Аймаг, сумын төвд	9 838	54.6	9 005	49.3
	Хөдөө	8 167	45.4	9 263	50.7
3	Сууцны тэрлэлт: Гэрт	12 111	67.3	12 243	67.0
	Байшинд	5 894	32.7	6 025	33.0
4	Сууцны нөхцөл: Тохилог сууцанд	1 900	10.6	1 980	10.8
	Сууцны тусдаа байшинд	3 608	20.0	3 767	20.6
	Гэр сууцанд	12 111	67.3	12 243	67.0
	Нийтийн байранд	383	2.1	271	1.5
	Орон сууцны бус	3	0.0	7	0.0
5	Халаалтын тэрлэлт: Төвлөрсөн	2 125	11.8	2 209	12.1
	Төвлөрсөн бус	280	1.6	289	1.6
	Бусад	15 600	86.6	15 769	86.3
6	Цахилгаан хангамж: Төвлөрсөн	10 171	56.5	10 263	56.2
	Бусад	7 817	43.4	7 994	43.8
	Байхгүй	17	0.1	11	0.1
7	Усан хангамж: Халуун, хүйтэн устай	1 152	6.4	1 230	6.7
	Үүнээс: Бие даасан систем	-	-	1	0.0
	Зөвхөн хүйтэн устай	16 853	93.6	17 038	93.3
	Үүнээс: Төвлөрсөн	905	5.0	921	5.0
	Бие даасан систем	-	-	2	0.0
	Зөөврийн	15 948	88.6	16 115	88.2
8	Хатуу хог хаягдал:				
	Үйлчилгээний байгууллагаар	7 212	40.1	7 258	39.7
	Зөвшөөрөгдсөн цэгт	3 016	16.8	3 089	16.9
	Тогтсон цэггүй	7 777	43.2	7 921	43.4
9	Бохир ус зайлуулалт:				
	Төвлөрсөн	2 035	11.3	2 122	11.6
	Бие даасан систем	3	0.0	6	0.0
	Бусад	15 967	88.7	16 140	88.4

Тодотгол: Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн зарим үзүүлэлтээс.



I.1.4 ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛ, сумаар

Сум	Төрсөн хүүхэд			Нас барсан хүн			Гэрлэлт			Цуцлалт		
	2016	2017	2018	2016	2017	2018	2016	2017	2018	2016	2017	2018
Асгат	37	51	41	11	14	9	6	11	7	2	1	-
Баяндэлгэр	111	102	98	32	26	26	34	29	15	5	5	3
Дарьганга	58	56	57	21	12	20	19	18	19	1	0	1
Мөнххаан	102	115	116	23	27	23	15	17	24	3	3	1
Наран	34	39	34	15	15	12	10	7	11	0	0	3
Онгон	89	65	80	20	20	17	21	10	20	1	3	0
Сүхбаатар	75	85	77	19	14	24	20	24	15	1	1	2
Түвшинширээ	96	91	82	13	16	14	19	15	11	0	1	1
Түмэнцогт	41	40	57	16	17	15	9	8	6	1	0	1
Уулбаян	73	52	84	17	15	13	12	16	23	1	1	1
Халзан	41	45	45	11	9	8	8	16	11	0	1	0
Эрдэнэцагаан	154	129	160	58	42	49	32	32	46	4	4	2
Баруун-Урт	590	596	633	99	94	46	167	129	144	25	42	23
Дүн	1 501	1 466	1 564	355	321	276	372	332	352	44	62	38

I.1.5 ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН, сумаар

Сум	Шилжиж ирсэн					Шилжиж явсан					
	Бүгд	Улаан-баатар	Дорнод	Дорно-говь	Бусад	Улаан-баатар	Дорнод	Хэнтий	Дорно-говь	Бусад	Бүгд
Асгат	19	6	1	1	11	-	-	-	-	14	14
Баяндэлгэр	36	14	6	12	4	5	-	4	31	7	47
Дарьганга	24	14	1	4	5	3	9	1	1	5	19
Мөнххаан	60	22	1	11	26	6	14	38	6	21	85
Наран	13	8	-	-	5	1	1	-	2	3	7
Онгон	47	17	1	10	19	13	1	7	6	2	29
Сүхбаатар	35	10	9	-	16	-	6	3	-	6	15
Түвшинширээ	65	8	1	18	38	1	7	32	7	5	52
Түмэнцогт	32	15	1	-	16	7	-	8	1	8	24
Уулбаян	25	19	-	-	6	6	2	11	-	2	21
Халзан	25	15	3	-	7	2	2	-	-	-	4
Эрдэнэцагаан	70	24	17	4	25	5	25	2	6	11	49
Баруун-Урт	251	142	40	14	55	56	37	9	47	50	199
Дүн	702	314	81	74	233	105	104	115	107	134	565
2017	779	348	93	81	257	199	100	149	92	86	626
2016	672	391	58	49	174	593	97	84	97	90	961
2015	905	451	129	102	223	567	90	120	61	62	900
2014	730	364	84	95	187	736	91	132	83	40	1 082
2013	778	426	88	73	191	711	119	82	99	102	1 113
2010-2018 онд	6 095	3 077	751	621	1 646	5 110	908	981	724	859	8 582



I.1.6 БҮТЭН ӨНЧИН ХҮҮХЭД, байршил, насны бүлгээр

Сум	2017	2018	Байршил			Насны бүлэг			
			Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	0-4	5-9	10-14	15+
Ас	1	1	-	-	1	1	-	-	-
Бд	-	1	-	1	-	-	-	-	1
Да	2	2	-	2	-	-	-	1	1
Мх	2	2	-	2	-	-	-	2	-
На	-	-	-	-	-	-	-	-	-
Он	1	1	-	1	-	-	-	-	1
Сб	2	-	-	-	-	-	-	-	-
Тш	2	2	-	-	2	-	-	1	1
Тц	7	5	-	5	-	-	-	2	3
Уб	1	1	-	1	-	-	-	-	1
Ха	-	-	-	-	-	-	-	-	-
Эц	6	7	-	4	3	-	1	1	5
Бу	8	8	6	-	2	-	1	2	5
Дүн	32	30	6	16	8	1	2	9	18

I.1.7 ХАГАС ӨНЧИН ХҮҮХЭД, байршил, насны бүлгээр

Сум	2017	2018	Байршил			Насны бүлэг			
			Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	0-4	5-9	10-14	15+
Ас	41	43	-	19	24	11	13	10	9
Бд	55	59	2	46	11	3	11	20	25
Да	30	35	-	22	13	1	9	12	13
Мх	32	38	1	25	12	4	10	13	11
На	14	14	2	5	7	5	1	2	6
Он	35	38	4	34	-	2	9	13	14
Сб	39	37	-	27	10	1	13	8	15
Тш	34	25	-	15	10	2	4	8	11
Тц	25	17	-	15	2	1	6	3	7
Уб	15	13	-	3	10	-	5	6	2
Ха	16	15	-	3	12	2	5	1	7
Эц	120	131	-	60	71	9	32	53	37
Бу	119	148	144	-	4	21	42	51	34
Дүн	575	613	153	274	186	62	160	200	191



I.1.8 ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ /ЭЦЭГ/, байршил, ам бүлийн тоогоор

Сум	2017	2018		Байршил			Насны бүлэг		
		Бүгд	Эмэгтэй	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	3 хүртэлх	3-5	6, түүнээс дээш
Ас	130	137	77	12	62	63	116	20	1
Бд	206	212	155	3	76	133	163	43	6
Да	121	136	111	-	116	20	123	13	-
Мх	304	223	177	17	112	94	101	109	13
На	29	49	40	-	30	19	36	13	-
Он	119	128	96	14	83	31	105	21	2
Сб	218	171	105	-	93	78	162	9	-
Тш	118	114	96	-	54	60	66	47	1
Тц	390	226	161	-	174	52	164	55	7
Уб	140	134	102	-	40	94	92	38	4
Ха	61	64	50	3	23	38	58	6	-
Эц	293	343	253	-	191	152	188	133	22
Бу	1 171	1 163	986	1 110	1	52	767	350	46
Дүн	3 300	3 100	2 409	1 159	1 055	886	2 141	857	102

I.1.9 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, байршил, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр

Сум	2017	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо			Хөгжлийн бэрхшээлийн төрөл								Төрөлхийн	Олдмол	Байршил		
		Бүгд	Эмэгтэй	Хөдөлмөр эрхэлдэг	Хараа	Хөдөлгөөн	Хавсарсан	Яриа	Сэтгэц	Сонсгол	Бусад	Нийслэл, аймгийн төв			Сумын төв	Хөдөө	
Ас	75	73	33	32	11	18	-	5	12	4	23	20	53	1	29	43	
Бд	249	244	101	2	35	50	-	12	50	24	73	102	142	2	101	141	
Да	103	118	46	55	17	21	9	3	29	14	25	38	80	-	67	51	
Мх	149	138	72	21	18	34	7	9	35	9	26	44	94	1	76	61	
На	91	89	28	15	15	21	3	5	17	6	22	29	60	1	40	48	
Он	177	159	65	56	38	27	16	4	24	20	30	52	107	-	80	79	
Сб	133	132	60	20	25	37	3	6	24	9	28	61	71	-	63	69	
Тш	151	152	63	21	15	35	7	3	25	19	48	65	87	-	91	61	
Тц	86	87	31	1	11	30	3	6	18	4	15	29	58	1	54	32	
Уб	127	122	40	23	20	19	1	4	33	8	37	34	88	-	28	94	
Ха	91	66	24	10	10	19	-	4	7	8	18	19	47	4	28	34	
Эц	258	263	109	37	36	104	13	9	54	13	34	89	174	-	131	132	
Бу	981	960	439	185	147	235	55	27	180	116	200	465	495	808	2	150	
Дүн	2 671	2 603	1 111	478	398	650	117	97	508	254	579	1 047	1 556	818	790	995	



1.2 ХӨДӨЛМӨР

1.2.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2014.XII	2015.XII	2016.XII	2017.XII	2018.XII	$\frac{2018.XII}{2017.XII}$ %
Асгат	33	3	27	14	24	171.4
